

**Гүн өрмийн худаг гаргах, худгийн барилга барих
ажил гүйцэтгүүлэх техникийн тодорхойлолт**


Уг ажлыг мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

д/д	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох		
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтооно.	
1.2	Цооногийн ундарга 0,6-1,2 л/сек багагүй байна.	
1.3	Суултын яндангийн материал нь ган буюу ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн хоолой нь ган буюу ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр нь 32 мм, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/ байж болно.	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн 2 м-ээс багагүй байна	
1.8	Худагт шавхалт хийх хугацаа 72 цагаас багагүй байна.	
1.9	Усны чанарт дээж авч шинжилгээ хийлгэсэн байна.	
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглох шаардлагатай	
2. Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих		
2.1	<ul style="list-style-type: none"> • Худгийн байшингийн хэмжээ: /дотор талдаа/ 3м х 3м, хананы өндөр шалнаас дээш 2м • Материал: тоосго, блок, модон • Хананы зузаан 38 см • Ханыг дотор талаас нь шавардаж, замаска тавьж, будна. • Худгийн барилгын дээврийн хэсэгт 30см х 30см хэмжээтэй нээлхийг цооногийн чанх дээд талд байхаар тохируулга хийнэ. Нээлхийг худгийг засварлахад ашиглана. • Худгийн цонх нь 80см х 80см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны чигт байрлана/ 	
2.2	Мал услах онгоцны ус өгөх хоолой нь 60мм-ийн диаметртэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолой, уян хоолойг цонхны доор гаргана.	

2.3	Ундны ус авах хоолой нь 32мм диаметртэй ган хоолой, буюу уян хоолойг цонхны доор гаргана. /Ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгоно/	
2.4	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,0-1,5 м ³ -ээс багагүй багтаамжтай ган, эсвэл хүнсний зориулалттай хуванцар усны сав, дээгүүрээ модон тагтай байна.	
2.5	Мал услах онгоцны: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой хагас цилиндр хэлбэртэй шинээр хийсэн байна. • Материал: Ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон • Онгоцыг худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 1м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт ус юлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана. • Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг мөлгөр болгож засна. 	
2.6	Мал услах талбай. <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: Онгоцны нийт уртын дагуу 2 талдаа тус бүр 1 м-ийн өргөнтэй 10 см зузаантай 150 маркаас доошгүй бетон хийцтэй талбай байна. • Мал услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юулэхэд тохиромжтой байршуулна. 	
3. Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар		
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна./хүчин чадал ямар байхыг тодотгох/	
3.2	Цахилгааны утас: 3 фазын худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно.	
3.3	Хянах самбар: Асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/, гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай байна.	

3.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна.	
4. Худгийн ажлыг дуусгах, хүлээлгэн өгөх		
4.1	Талбайг цэвэрлэнэ./Өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/	
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалтыг худаг ашиглагч нарт хийнэ.	
4.3	Худгийн паспортыг бэлтгэж, баталгаажуулан сумын ЗДТГ-т хүлээлгэн өгнө.	
4.4	Цахилгаан үүсгэвэр, насосны ашиглалтын болон аюулгүйн ажиллагааны зааврыг хананд байршуулсан байна.	
4.5	Ус гарах боломж нөхцлийг бүрэн тооцож өрөмдлөг хийх ба ус гарахад учирч болох эрсдэлийг сонгон шалгаруулалтанд оролцсон компани хариуцна.	

Хянасан:
ХБТХОХ-ийн дарга



Д.Азжаргал

Боловсруулсан:
ХБТХОХ-ийн мэргэжилтэ

Б.Баярмаа